



## ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР

# ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН


2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр

## 2021 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

### НЭГ. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

**НХТЖҮЧ-ийн 9. НЗДҮАХ-ийн 6.1.1. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж үе шаттай хэрэгжүүлэх ажлын хүрээнд:**

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/860 дугаар захирамжаар хийгдэж буй “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний эхлэлийн тайлангийн материалыг хүлээн авч одоо байгаа шугам сүлжээний мэдээлэл, ирэх 5 жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний мэдээллийг гарган өгч, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дундын болон эцсийн тайлангийн инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэлд санал өгч тусгуулсан. Нийслэлийн Засаг даргын захирамжаар нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн хэлэлцүүлэгт 2021 оны 09 дүгээр сарын 20-24 хооронд оролцож зөвлөх үйлчилгээний инженерүүд, төлөвлөлтийн инженерүүд, шугам сүлжээний хангагч байгууллагын ерөнхий инженерүүдийг оролцуулж




санал зөвлөмжийг тусгуулав. Мөн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж буй зөвлөх үйлчилгээний байгууллагын зохион байгуулсан “Дулаан хангамж, цахилгаан хангамж, хий хангамж, сэргээгдэх эрчим хүч”, “Ус хангамж, ариутгах татуурга, инженерийн бэлтгэл арга хэмжээ”-ний хэлэлцүүлэгт орж санал хүргүүлсэн. Нийт 31 байгууллагаас саналыг авч нэгтгэн хүргүүлсэн.

**НЗДҮАХ-ийн 6.1.1.2. Хот байгуулалтын баримт бичиг, зураг төсөл, ТЭЗҮ, мастер төлөвлөгөөг боловсруулж үе шаттай хэрэгжүүлнэ.**

Агаар орчны бохирдлыг бууруулах гэр хорооллын “Хөгжлийн үүд төсөл”-ийн хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах чиг үүргийн хүрээнд Барилгажилтын төслийн

*инженерийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөлтийн шийдэл, хөрөнгө оруулалтын тооцоог хянан зөвшилцөх ажлын хүрээнд:*

“Хөгжлийн үүд” төслийн хүрээнд хийгдэж буй Хан-Уул дүүргийн Морин даваа орчмын шинэ суурьшил, Баянзүрх дүүргийн Хонхор хаяа хот орчмын шинэ суурьшлын бүсийн төслийн гадна инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн шийдэл, зураг төсөл, угсралтын хөрөнгө оруулалтын тооцоог гаргав.



Морин даваа орчмын шинэ суурьшлын бүсийн эхний ээлжийн 34 га талбайд хэрэгжих төслийн инженерийн шугам сүлжээний ажлыг зураг төслийг зөвшилцөж дууссан. Барилга угсралтын ажил хийгдэж байна. Тус төлөвлөлтийн дагуу 21МВт-ын дулааны эх үүсвэрийн техник эдийн засгийн үндэслэл Эрчим хүчний яамны шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн V дугаар хуралдааны 04 дүгээр тэмдэглэлээр батлагдсан. Төслийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний ажилд санал хүргүүлж, ажлын зураг төсөл зөвшилцсөн.

*9.2 “Барилгын материалын бөөний худалдааны төв”-ийн ТЭЗҮ, ХЕТ боловсруулах ажлын даалгаварт инженерийн дэд бүтцийн хангамжийн хэсгийн санал боловсруулах, даалгаврын дагуу инженерийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөлтийн шийдэл хөрөнгө оруулалтын тооцоог хянан зөвшилцөх ажлын хүрээнд:*

“Барилгын материалын бөөний худалдааны төв”-ийн инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн даалгаврыг боловсруулан Ерөнхий архитекторын ажлын албанд өгсөн.

*10.1 Нийслэлийн ногоон бүс /зуслан/-ийн 4 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх ажлын даалгаварт инженерийн дэд бүтцийн хангамжийн хэсгийн санал боловсруулах, даалгаврын дагуу инженерийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөлтийн шийдэл хөрөнгө оруулалтын тооцоог хянан зөвшилцөх ажлын хүрээнд:*

Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороо, Бэлх, Сэлхийн амны үерийн зуслангийн бүсийг үерийн эрсдэлээс хамгаалах барилга байгууламжийн төлөвлөлтийн шийдэл, хөрөнгө оруулалтын тооцоо гаргаж тухайн тойргоос сонгогдсон Улсын Их Хурлын гишүүнд

хүргүүлсэн. Нийслэлийн ногоон бүс зуслангийн 4 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаварт санал хүргүүлсэн.

**15. ЗГҮАХ-ийн 6.1.3, НЗДҮАХ-ийн 6.1.9.Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах ажлын хүрээнд:**

Төсөл хэрэгжиж буй байршлын ажлын явцын судалгааг гаргаж, төсөл хэрэгжүүлэгч шалгарсан багцуудын гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, угсралтад шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоог нэгтгэн гаргаж НЗДТГ-ын ХБТХ-т 2021 оны 06/826, 06/1141, 06/1477 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Хөрөнгө оруулалтын ажлын саналыг 2021 оны улс, нийслэлийн төсвийн тодотгол болон 2022 оны улс, нийслэлийн төсөвт тусгуулахаар танилцуулга бэлтгэж НЗДТГ-ын ХБТХ-т хүргүүлсэн.

Гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын нийт **11 багц төслийн 35** барилга хөрөнгө шийдвэрлэгдсэн. **9,9 тэрбум төгрөг** /Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө/

Гадна инженерийн ажлын зураг төсөлтэй нийт **18 багц төсөл 26,7 тэрбум төгрөг**



Нэн яаралтай шийдвэрлэх шаардлагатай **2 багц төсөл 2,3 тэрбум төгрөг**



Төслийн хүрээнд 2020 оны байдлаар 531 өрхийн 33 орон сууцныг буулгаж **1556 өрхийн 13 орон сууцны барилгыг** ашиглалтад оруулж 215 айлыг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл хангагдсан.

2016 он 38 айл 8 барилга,	377 айл, 3 блок барилга
2018 он 80 айл 10 барилга,	301 айл, 3 блок барилга
2019 он 104 айл 13 барилга,	518 айл, 5 блок барилга
2020 он 97 айл 2 барилга,	360 айл, 2 блок барилга
нийт <b>231 айл, 33 барилга</b>	<b>1556 айл, 13 блок барилга</b>



Нийслэлийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/803 дугаар захирамжаар ХУД-ийн 20 дугаар хороо, БГД-ийн 4 дүгээр хороо, Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны нийт 3 байршлын дэд бүтэц, гадна инженерийн шугам сүлжээнд нийт 1,932.6 сая.төгрөг батлагдсан. Захирамжийн хүрээнд батлагдсан ажлын зураг төслийг НХААГ-т 2021 оны 06/3547 дугаартай албан бичгээр, зураг төсөл хүлээлцэх актын дагуу хүлээлгэн өгөв. Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна.

Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороонд байрлах ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн орон сууцны СОТ-ын 3, 8, 9, 10, 11 дүгээр байрны төсөл хэрэгжүүлэгч “Эх газрын жигүүр” ХХК-ийн төслийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний техникийн нөхцөл олгогдож, дулаан хангамж, цахилгаан хангамжийн техникийн нөхцөл олгох асуудлыг ЭХЯ болон УБДС ТӨХК, УБЦТС ТӨХК-д төлөвлөлтийн шийдэл хүргүүлж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Хан-уул дүүргийн 2,3 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж байгаа Нэхмэлийн шарын барилгуудын гадна бохир усны шугамын барилга угсралтын ажлын явцад үүссэн


авто замын сэтэлгээ, аж ахуйн нэгжийн газар чөлөөлөлтийн асуудал, ажлын зураг төсөлд тусгагдсан холболтын цэгийн өөрчлөлт зэрэг асуудлыг холбогдох байгууллалатай хамтран шийдвэрлэж ажилласан.

Баянгол дүүргийн 5 дугаар хороонд байрлах ашиглалтын шаардлага хангахгүй 7, 8, 9 дүгээр байрнуудыг буулган дахин барилгажуулах төсөлд шаардлагатай дулаан хангамжийн техникийн нөхцөлийг хангагч байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлсэн. (Төсөл хэрэгжүүлэгч нь “Нутгийн буян” ХХК, “Тэргүүн чансаа” ХХК)

Нийслэлийн 2022 төсвийн саналд ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган барилгажуулах 18 багц төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсвийн шаардлагатай хөрөнгийг нэгтгэн боловсруулж, батлагдсан ажлын зураг төсөв, магадлалын дүгнэлтийн хамт НЗДТГ-ын ХБТХ-т хүргүүлсэн.


**18. НЗДУАХ-ийн 6.3.20. Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө болон өндөржилтийн нэгдсэн зураг төсөл боловсруулан батлуулах ажлын хүрээнд:**

Улаанбаатар хотын Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Пристиж инженеринг” ХХК шалгарч, 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Барилга, Хот байгуулалтын яамтай гэрээ байгуулсан. Зөвлөх үйлчилгээний компаниас ирүүлсэн хүсэлтийн дагуу батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, төсөл хөтөлбөр, зураг төслийн мэдээллийг нэгтгэн хүргүүлсэн. Зөвлөх үйлчилгээний байгууллагаас дундын тайланг ирүүлснийг хянаж, санал хүргүүлэв.



Өндөржилтийн нэгдсэн зураг төсөл боловсруулах Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Инженер геодези” ХХК шалгарч, 2021 оны 02 дугаар сарын 11-ны өдөр

Барилга, хот байгуулалтын яамтай гэрээ байгуулсан. Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй байгууллагаас ирүүлсэн ажлын дундын болон эцсийн тайлангийн төлөвлөлтийн шийдэлд санал өгч Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ажилласан. Төлөвлөлтийн үерийн хамгаалалтын далан суваг, авто замын борооны ус зайлуулах шугам сүлжээ, ус урсах гуу жалга, ус хураах талбайн зураглал, тайланд санал өгч, зөвшилцөж ажилласан. Захиалагчийн хяналтыг Барилга, Хот байгуулалтын яам гүйцэтгэж байна.



**19. НЗДҮАХ-ийн 6.3.21.2. Голуудын эрэг болон үерийн хамгаалалтын далан, суваг, шугам сүлжээг шинээр барих болон өргөтгөн шинэчлэх ажлын хүрээнд:**

Доод Өлзийтийн ам, Сонгино амралт, суурьшлын бүсийн Туул голын орчмын үерийн хамгаалалтын далангийн зураг төсөл, Төв цэвэрлэх байгууламжийн бохир ус Туулд голд нийлдэг хэсгийн эргийн хамгаалалтын далангийн зураг төсөл нийт 4 байршилд 18.6 км үерийн хамгаалалтын сувгийн төлөвлөлтийн шийдэл зураг төслийг хянан зөвшилцөв.

**20. НЗДҮАХ-ийн 6.3.24.1. Хужир булан, Толгойт Их наран, Буянт-Ухаа 2 хороололд шинээр усан сан, шугам сүлжээ барьж ашиглалтад оруулна. Их Нарангийн зураг төслийн ажлын хянан зөвшилцөнө.**

Улсын төсвийн хөрөнгөөр ажлын зураг төсөл хийгдэж байгаа Толгойт, Их наран, Буянт ухаа-2- хорооллын шугам сүлжээний ажлын зураг төслийг “Хайдродизайн инноваци” ХХК гүйцэтгэсэн бөгөөд ажлын зураг төслийг зөвшилцөн баталгаажуулж мэдээллийн санд оруулав. Үүнд :

- Сонгинохайрхан дүүргийн 4 хороо Их Нарангийн авто зам дагуу Баянхошуу коллектор хүртэл хийгдэх ариутгах татуургын ф400мм ийн 2,8 км шугамын ажлын зураг төсөл
- Буянт-Ухаа-2 хорооллын 2 дугаар ээлжийн төслийн ариутгах татуургын шугамын 1,3 дугаар ээлжийн ажлын зураг төсөл ф500/ф600 мм-ийн 2.1 км шугамын зураг төслийн ажил

- Сонгинохайрхан дүүргийн 2, 3, 26, 35, 36 хороо Толгойт, Их Нарангийн гэр хорооллын ус хангамжийн ф150-ф250 мм ийн голч бүхий 17,0 км 3 хос цагираг сүлжээ, 2х1000м<sup>3</sup> хүчин чадал бүхий усан сан, насос станцын ажлын зураг төслийг хянаж баталгаажуулсан

**21. НЗДҮАХ-ийн 6.3.24.2. Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг шинээр барьж ашиглалтад оруулах ажлын хүрээнд:**

Төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний нийт 322 зураг төслийг хянан зөвшилцөв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг боловсруулан техникийн нөхцөлийн хурлаар хэлэлцүүлэн баталж, ажлын зургийн даалгавар боловсруулан баталж Барилга, Хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Үүнд:

- Хан-Уул дүүргийн 10 дугаар хороонд байрлах Солонго-1, Солонго-2 орон сууцны хороолол
- Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Залуус-1 орон сууцны хороолол
- Баянгол дүүргийн 9, 10, 11, 21, 22, 23, дугаар хорооны гэр хорооллын хэсэгт хийгдэх инженерийн шугам сүлжээ
- Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг шинээр барьж ашиглалтад оруулах чиглэлээр нийслэлийн хэмжээнд 7 байршилд нийтийн бие засах газрын гадна ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ
- Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар хороонд байрлах гэр хорооллын дахин төлөвлөлтийн 3,8 га нэгж талбарын гадна ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ
- Багахангай дүүргийн дэд бүтцийн төвийн байршилд хийгдэх инженерийн шугам сүлжээ  
Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа ус хангамж, ариутгах татуургын дараах шугам сүлжээний ажлын зураг төслийг хянаж баталгаажуулсан.
- Гэмтлийн эмнэлгийн бохир усны салбар шугамын өргөтгөлийн ажлын зураг төсөл 316 дүгээр коллекторын ажил
- Дарь эхийн ариутгах татуургын ф300-ф400 мм-ийн 4,8 км шугам
- Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх БГД-ийн 9, 10, 11, 21, 22, 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт хийгдэх цэвэр бохир усны шугам
- Богдзонхав хөшөө цогцолбор төслийн гадна инженерийн шугам
- Туул голын эрэг дагуу хийгдэх тохижилтын ажлын 7 байршлын шугам
- Дэлгэрэх хотхоны цэвэр усны холбоос шугамын ажил, Төв цэвэрлэхээс үйлдвэрийн эх үүсвэр хүртлэх цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх ажлын зураг төсөл

**22. НЗДҮАХ-ийн 6.3.29.6. 50 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барих ажлын хүрээнд:**

Эрчим хүчний яамны 2021 оны 02 дугаар сарын цахилгааны техникийн нөхцөл олгох цахим хурлаар Улаанбаатар хотын баруун хэсэгт барих 50 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станцын асуудлыг хэлэлцэж, “Сонгино 2020/110/35кВ-ын дэд станц”-ын дэргэд суурилуулан байгуулахаар дэмжиж баталсан.

“Налайх-110/10кВ-ын дэд станц”-ын дэргэд баригдах цахилгаан цэнэг хураагуурын станцад 2020/27-36 дугаартай Архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан

**23. НЗДҮАХ-ийн 6.3.31.1. Налайх дүүрэг, Дамбадаржаа, Сэлбэ дэд төвийн дулааны станц шинээр барьж, ашиглалтад оруулах ажлын хүрээнд:**

Дамбадаржаа дэд төвийн дулааны эх үүсвэрийн техник эдийн засгийн үндэслэл Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2020 оны 05 дугаар 20-ны 06 дугаар хурлын тэмдэглэлээр батлагдсан. Гадна дулаан хангамжийн шугам сүлжээний 2020/35-20 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар олгосон. Дамбадаржаа дэд төвийн дулааны эх үүсвэрийн техник эдийн засгийн үндэслэл, гадна дулааны шугамын ажлын зураг төслийг зөвшилцсөн.

Дэнжийн 100 дэд төвийн хий хангамжийн 80Гкал/цаг-ийн эх үүсвэрийн ТЭЗҮ боловсруулах 2020/Д-44 дугаартай даалгавар боловсруулсан баталсан. Дэд төвийн



дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ нь Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2020 оны 05 дугаар хуралдааны тэмдэглэлээр батлагдсан бөгөөд төлөвлөж буй эх үүсвэрийн ТЭЗҮ, гадна дулаан хангамжийн шугам сүлжээний ажлын зургийг зөвшилцсөн.

**24. НЗДҮАХ-ийн 6.3.32.1. Төвлөрсөн дулаан хангамжийн системийн төв шугамуудыг өргөтгөн шинэчлэх ажлын хүрээнд:**

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн гол магистраль шугам сүлжээний ашиглалтын хугацаа дууссан санхүүжилт шийдвэрлэгдээгүй гадна дулааны өргөтгөл, шинэчлэлтийн ажлын зураг төсөл зөвшилцсөн. Үүнд:



- Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, 2а магистралийн ДХ-223-р цэгээс ДХ-223-1-р цэгийн хооронд 2ф200мм 67у/м дулааны шугам
- СБД 8-р хороо, БЗД-ийн 1-р хороо, 2б магистраль 2ф300мм-ийн голчтой 290у/м;
- БЗД-ийн 3 дугаар хороо 2ф300/350мм-ийн голчтой 680у/м;
- ЧД-ийн 2-р хороо, 3б магистраль, ДХ-321 цэгээс 2ф200мм голчтой 160у/м;
- БЗД-ийн 6-р хороо, 5г магистраль ДХ-5118-р цэгээс ДХ-5124-р цэгийн хооронд 2ф500мм-ийг өргөтгөж 2ф720мм-ийн голчтой 193у/м;
- 5д магистраль ДХ5142 цэгээс ДХ5149 цэгийн хооронд 2ф400мм голчтой 191 у/м;
- ЧД-ийн 4-р хороо, Ялалтын талбайн зүүн талд 6б магистраль ДХ-632-12 цэгээс ДХ-632-14-р цэгийн хооронд 2ф200мм 340 хос.км;
- СХД-ийн 20-р хороо, Оргил худалдааны төвөөс зүүн тийш 9б магистралийн ДХ-935-13 цэгээс ДХ-935-9 цэгийн хооронд 2ф300мм-ийн 190 хос.км;
- БГД-ийн 20-р хороо, Мокон ХХК-ийн хойд талд 10б магистраль, ИЗ-1029-12 цэгээс ИЗ1029-14-р цэгийн хооронд 2ф400мм голчтой 100хос.км;
- БГД-ийн 20-р хороо, Эрин хорооллын зүүн талд 11в магистраль, ДХ-1145-р цэгээс ДХ-1147-р цэгийн хооронд өгөх 1ф1000мм-ийн голчтой 308 хос.км, **НИЙТ 2241 хос.км** дулаан шугамын ажлын зураг төсөл зөвшилцсөн.


**25. НЗДУАХ-ийн 6.3.32.2. Төвлөрсөн дулаан хангамжийн системийн шугам сүлжээг шинээр барьж, нэмэгдүүлэх ажлын хүрээнд:**

Өргөтгөн шинэчлэх Европийн сэргээн босголтын банкны санхүүжилтээр хийгдэх:

- 8а,б,в,г магистраль 2ф600мм-ийн 3.2 хос.км дулааны шугам;
- ДХ1216 цэгээс ПХ589 дугаар цэг хүртэл 5в-12а магистралийн холбоос шинээр 2ф600мм-ийн 0,5хос.км, **НИЙТ 3.7хос.км** дулааны шугамын ажлын зураг төслийг зөвшилцсөн.

Дэлхийн банкны санхүүжилтээр хийгдэх:

- 5а магистраль ДЦСЗ ХК-иас Тк-1699 цэг хүртэлх 2ф800мм-ийн голчтой дулааны шугамыг 2ф1000мм болгож өргөтгөх 2,8км дулааны шугам,
- 3г магистраль Тк-521-ээс Тк-328 цэг хүртэлх 1Ф600, 2Ф400мм-ийн голчтой дулааны шугамыг 2Ф700мм болгож өргөтгөн шинэчлэх 1,3 хос.км, **НИЙТ 4.1 хос.км** шугамын ажлын зураг төслийг зөвшилцсөн байна.




Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/527 дугаар захирамжаар зөвлөх үйлчилгээний хөрөнгө шийдвэрлэгдсэн. Тус ажлын хүрээнд төвлөрсөн дулаан хангамжийн системийн төв шугамын ажлын зургийн даалгаврыг 5 байршилд боловсруулан баталж Эрчим хүчний яам, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-д хүргүүлэв. Үүнд:

- ХУД-ийн 10 дугаар хороонд төлөвлөж буй Солонго-1 хорооллын гадна дулаан хангамж;
- ХУД-ийн 10 дугаар хороонд төлөвлөж буй Солонго-2 хорооллын гадна дулаан хангамж;
- Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Залуус-1 нэгж хорооллын гадна дулаан хангамж.
- Налайх дүүргийн 5 дугаар хороо, Гордокийн дулааны эх үүсвэрийн техник эдийн засгийн үндэслэл, гадна дулааны шугамын ажлын зургийн даалгавар,
- Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Залуус-1 нэгж хорооллын гадна дулаан хангамжийн ажлын зургийн даалгавар боловсруулан батлуулсан.

## 26. НЗДҮАХ-ийн 6.3.33.2. Хийн түлшний дулааны эх үүсвэрүүдийг барьж байгуулна.

Чингэлтэй дүүргийн 10, 11, 12, 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 617.5 га талбайд Дэнжийн 1000 дэд төв төлөвлөгдсөн.

Нисэх, Яармагийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний VII, VIII дугаар бүсэд дулаан хангамжийн төлөвлөлтийн шийдэл боловсруулан Хотын орлогч даргад танилцуулах



материал бэлтгэсэн.

Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо Залуус орон сууцны цогцолбор хорооллын 80Гкал/цагийн дулаан хангамжийн эх үүсвэрийн ТЭЗҮ ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг боловсруулан Эрчим хүчний яамаар батлуулан Барилга, Хот байгуулалтын яаманд хүргүүлсэн

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах дулааны эх үүсвэрийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах судалгааны ажилд Баянзүрх дүүргийн 19, 24 дүгээр хороо Шархад дэд төв орчимд төлөвлөж буй 112 Гкал/цаг, Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо 31 дүгээр нэгж хороолол орчимд төлөвлөж буй 80 Гкал/цаг, Хан-Уул дүүргийн 8 дугаар хороо 27 дугаар нэгж хороолол орчимд төлөвлөж буй 80 Гкал/цаг, Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо Авто худалдааны төв орчим, Шинэ хотын төв орчимд төлөвлөж буй 80 Гкал/цаг, Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хороо Ханын материал орчимд төлөвлөж буй 40 Гкал/цаг, нийт 392 Гкал/цаг-ийн хэсэгчилсэн дулаан хангамжийн эх үүсвэрийг байршлыг тусгуулахаар санал боловсруулан 2021 оын 12 дугаар сарын 01-ны өдрийн 06/3950 дугаартай албан бичгээр Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнд хүргүүлсэн.

Шархад дэд төвийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хийгдэх Амгалан дулааны станцтай хослон ажиллах 80Гкал/цагийн хүчин чадалтай дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ-ний ажлын даалгаврыг батлуулахаар Эрчим хүчний яаманд 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 06/3951 дугаартай албан бичгээр хүргүүлэв.

**27. НЗДҮАХ-ийн 6.3.33.3. Төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжгүй аж ахуйн нэгж, байгууллагын хатуу түлшний халаалтын зуухнуудыг хийн түлшинд шилжүүлэх ажлын хүрээнд:**

Нийслэлийн хэмжээнд хатуу түлшээр ажилладаг уурын зуухны судалгааг гаргасан. Хатуу түлшээр ажилладаг уурын зуухтай төрийн өмчийн сургууль цэцэрлэгийн барилгыг хийн хангамжийн системд шилжүүлсэн судалгааг гаргаж Хот байгуулалтын мэдээллийн санд байршлаар нь бүртгэл үүсгэв.

**ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД:**

23 дугаар нэгж хороолол, Багануур, Багахангай үйлдвэр технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг хянан зөвшилцсөн.

Дэнжийн 1000 дэд төв, Дамбадаржаа дэд төвийн инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн шийдэл, хөрөнгө оруулалт, үр ашгийн тооцоог хянаж, ажлын зураг төслийг хянан зөвшилцсөн.

АНУ-ын Мянганы сорилын сангийн буцалтгүй тусламжаар хийгдэх доод эх үүсвэрийн ус хангамжийн төслийн барилга байгууламж, шугам сүлжээний нарийвчилсан зураг төслийн ажлыг АНУ-ын АЙКОМ компани, үндэсний зөвлөх “Престиж инженеринг” ХХК хамтран гүйцэтгэж зөвшилцсөн.

Барилга, Хот байгуулалтын яамны захиалгаар “Залуус-1” нэгж хороолол, “Солонго-1”, “Солонго-2” нэгж хорооллын гадна инженерийн шугам сүлжээний хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулав.



Баянзүрх дүүргийн 8, 9, 10, 17-р хороо, 42 га талбай, Сүхбаатар дүүргийн 20-р хороо, 2.4 га

талбай, Сонгинохайрхан дүүргийн 29.9 га талбайд байнгын ундаргатай булгаар тэжээгдэж буй голын ай сав орчмын гадаргын усыг хуримтлуулж өв цөөрөм үүсгэх тохижилтын ажлын төлөвлөлтийг Хот дахин хөгжүүлэх хэлтэстэй хамтран боловсруулсан.

Зайсан хорооллын цэвэр усны гадна шугамын ажлын зураг төслийг “Инж байгууламж” ХХК боловсруулан ирүүлснийг хянан зөвшилцсөн.

Монгол Улсын Засгийн газраас тэргүүлэх салбаруудад хэрэгжүүлэх 100 төсөл, арга хэмжээнд тусгуулах төсөл, арга хэмжээний мэдээлэлд инженерийн дэд бүтцийн төсөл арга хэмжээнд шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоог боловсруулан, танилцуулга бэлтгэсэн.

*Дүрмээр хүлээсэн ажил үүргийн чиглэлээр:*

*Инженерийн дэд бүтцийн ажлын зураг төсөлтэй зөвшилцсөн байдал:*

✓ Дулаан хангамж	269
✓ Усан хангамж ариутгах татуурга	322
✓ Цахилгаан хангамж	281
✓ Харилцаа холбоо	192
✓ Инженерийн бэлтгэл арга хэмжээ	30 буюу нийт 1094

*Инженерийн дэд бүтцийн ажлын зургийн даалгавар өгсөн байдал:*

✓ Дулаан хангамж	16
✓ Усан хангамж ариутгах татуурга	10
✓ Цахилгаан хангамж	10
✓ Харилцаа холбоо	7
✓ Инженерийн бэлтгэл арга хэмжээ	21 буюу нийт 64

*Техникийн нөхцөлийн хуралд оролцсон байдал:*

- ✓ Эрчим хүчний яамны дулааны эрчим хүчээр хангах 8 удаагийн, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн дулааны эрчим хүчээр хангах 3 удаагийн
- ✓ Төвлөрсөн усан хангамжийн сүлжээнд холбогдох 21 удаа
- ✓ Цахилгааны эрчим хүчээр хангах Эрчим хүчний яамны 8 удаагийн хуралд, УБ ЦТС ТӨХК-ийн эрчим хүчээр хангах хуралд 5 удаа тус бүр оролцож, санал дүгнэлт гаргаж ажилласан.

46989 метр инженерийн шугам сүлжээний трассыг хот байгуулалтын мэдээллийн санд оруулсан. Үүнд:

- Дулааны шугам 5196м
- Бохир усны шугам 11994м
- Инженерийн бэлтгэл арга хэмжээ 29799м

Хот байгуулалтын мэдээллийн сан дахь инженерийн дэд бүтцийн мэдээллийн сангийн төлөвлөгдсөн хэсгээс хийгдэж ашиглалтад орсон инженерийн шугам сүлжээний мэдээллийг тулгаж, мэдээллийн сангаас устгаж баяжилт хийсэн.

Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг шинэчлэх ажлын хүрээнд хангагч байгууллагууд руу мэдээллийн санг шинэчлэх тухай албан бичиг хүргүүлж, ЦДҮШ ТӨХК-тай хамтран ЦДАШ-ын хамгаалалтын зурвасыг шинэчлэн оруулсан. Инженерийн шугам сүлжээний тулгалтын ажил хийгдэж байна.

*Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууц барилгыг дахин төлөвлөн барилгажуулах ажлын хүрээнд:*

Монгол улсын Засгийн газрын 2018 оны Н/206 дугаар “Газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор батлагдсан нийт 58 барилгыг буулган шинээр барих төслийн хүрээнд гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл, хөрөнгө оруулалтын тооцоог гаргаж ХДХХ-т хүргүүлж ажилласан.

Төсөл хэрэгжүүлэгч “Шинэ гэр түншлэл” ХХК-ийн хүсэлтийн дагуу Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 36а, б байрны гадна инженерийн ажлын зураг төслийг хүргүүлсэн.

Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт ашиглалтын шаардлага хангахгүй 51, 52 дугаар барилгыг буулган шинээр барих төсөл хэрэгжүүлэгч “Эм Ти Эм Сити инженеринг” ХХК-иас ирүүлсэн албан бичгийн дагуу гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах хөрөнгийг Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх шаардлагатай зураг төслийн ажлын задаргаанд хүргүүлсэн.

Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Үйлдвэр хоршооллын 12 дугаар байрыг буулган, дахин шинээр барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчээр “Монтед констракшн” ХХК-ийн шинээр барих үйлчилгээтэй 48 айлын орон сууцны барилгын техникийн нөхцөлүүдийг авч, гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсвийг боловсруулж Барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгэн манай байгууллагад ирүүлсэн. Угсралтын хөрөнгийг 2021 оны тодотголд оруулах шийдвэрлүүлэх тухай НЗДТГ-ын ХБТХ-т албан бичгээр хүргүүлсэн.

*Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд:*

Нийслэлийн Засаг дарга гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгчтэй уулзах уулзалтын хүрээнд гэр хорооллын дахин төлөвлөлтийн гадна инженерийн шугам сүлжээний хийгдсэн ажил, цаашид шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоо жагсаалтыг гаргаж нэгтгэсэн.

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 5, 6, 7-р хорооны нутаг дэвсгэр “Ханын материал” орчим нийт талбай 130 га, Сонгинохайрхан дүүргийн 10-р хорооны нутаг дэвсгэр “Арьс ширний ажилчдын байр” орчим нийт талбай 11.5 га талбайн гэр хорооллын дахин барилгажуулах ажлын даалгаварт санал өгч ХДХХ-т хүргүүлэв.

Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэр 25.3 га нэгж талбарт хэрэгжиж буй “Батхэрэйд” ХХК-ийн төслийн дэд бүтэц, гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийг зөвшилцсөн. Баяндүрх дүүргийн 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 11.6 га нэгж талбарт хэрэгжиж буй “Шинэ гэр түншлэл” ХХК, Сонгинохайрхан дүүргийн 23 дугаар хороо

Шинэ оргил төслийн 24,0 га нэгж талбарын дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг хянан мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан.

*“Дэд төв”-ийн төслийн хүрээнд:*

Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн хэрэгжүүлж буй 10 дэд төвийн мэдээлэл холбоо, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, цахилгаан хангамж, үерийн хамгаалалтын шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл, томсгосон хөрөнгө оруулалтын тооцоог гарган нэгтгэж холбогдох байгууллагад хүргүүлэв.

Чингэлтэй дүүргийн 7 хорооны нутагт баригдсан Дэд төвийн барилга байгууламжийн ашиглалтын хүрээнд гарсан Мэргэжлийн хяналтын дүгнэлтийн дагуу зөрчил арилгах албан тоотыг Захирагчийн ажлын албанаас ирүүлснийг судалж 2021 оны 06/1022 тоот албан бичгээр хариу өгч цэвэрлэх байгууламж, халаалтын зуухны хамгаалалтын бүсийг тогтоож Газар зохион байгуулалтын албанд хүргүүлэв.

Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгжийн хүрээнд хийгдэж буй Шархад, Толгойт олон нийтийн дэд төвийн инженерийн дэд бүтцийн ажлын зургийн даалгаврыг Мэргэжлийн зөвлөлийн 07 дугаар хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн.

*Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар :*

Худалдаа үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлж байгаа иргэдийн QR кодоор хянах үйл ажиллагааг зохион байгуулж байгаа байдалд нийслэлийн агентлаг, харьяа байгууллагуудын хяналт тавьж ажиллах хуваарийн дагуу 2021 оны 01 сарын 28, 29-ны өдөр ХУД-ийн 15 дугаар хороо, 2021 оны 02 дугаар сарын 11, 13-ны өдрүүдэд ХУД-ийн 11 дүгээр хороонд ажилласан.

Монгол улсын Засгийн газраас тэргүүлэх салбаруудад хэрэгжүүлэх 100 төсөл, арга хэмжээнд тусгуулах төсөл, арга хэмжээний хүрээнд ашиглалтын шаардлага хангахгүй барилгын дахин төлөвлөн барилгажуулах 96 барилгын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын төслийн танилцуулгыг бэлтгэв.

Агаарын бохирдолтой тэмцэх газрын боловсруулж буй Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.3 дахь хэсэгт заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хамтарсан тушаал, захирамжийн хүрээнд боловсруулж буй Агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журмыг шинэчлэн батлах тухай журмын төсөлд санал боловсруулж хуулийн хэлтэст хүргүүлсэн.

Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 3 дэд төв, 10 олон нийтийн дэд төвийн дэд бүтцийн төлөвлөлтийн шийдэл, хөрөнгө оруулалтын тооцоог боловсруулан нэгтгэж танилцуулга материалд тусгуулсан.

Богдзонхав хөшөө цогцолбор төслийн гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл боловсруулж, хөрөнгө оруулалтын тооцоо гаргаж танилцуулга бэлтгэв.

Баруун зүүн салааны байнгын ундаргатай булаг, рашаан, Толгойт голын ай сав дагуух төсөл, үерийн хамгаалалтын байгууламжийн нэгдсэн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын тооцоо, газар ашиглалтын судалгааг нэгтгэн танилцуулга бэлтгэж удирдах албан тушаалтан болон Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлж ажилласан.



Энхтайваны өргөн чөлөө дагуу Метроны 27,5 км трасс гаргаж, трассын дагуух шугам сүлжээний мэдээллийг хангагч байгууллагаас тодруулан гаргаж боловсруулалт хийж ажилласан.

Зайсан хорооллын цэвэр бохир усны шугам сүлжээний одоогийн байдал хэрэгжүүлж байгаа шугам сүлжээний ажлын мэдээллийг нэгтгэж, цаашид хийх боломжтой шугам сүлжээний шийдэл гарган төсөвт өртгийг тооцож ЗАА-нд хүргүүлсэн.

Төв цэвэрлэх байгууламжид ирж буй хаягдал усны эх үүсвэр, шинж чанарыг тодорхойлж, хаягдлын мэдээллийн сан бий болгох ажлын хүрээнд суурин болон явуулын лаборатори ажиллуулах бэлтгэл ажлын хөрөнгө шийдэгдээгүй. Ус сувгийн удирдах газраас эхний хагас жилд 34 үйлдвэр, 23 хэрэглэгчийн хаягдал бохир уснаас шинжилгээ авч, арьс шир боловсруулах 11 үйлдвэрүүдэд хяналт хийж, дүгнэлт гаргасны дагуу Монголын арьс ширний холбоонд хаягдал ус урьдчилан цэвэрлэх байгууламжийн технологийн шийдэлд санал, зөвлөмж хүргүүлж ажилласан.

Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо, Хөдөө аж ахуйн хангамжийн ажилчдын орон сууцны 27 дугаар байрны иргэдтэй очиж уулзсаны дагуу дулааны эрчим хүчний тусгай зөвшөөрөлтэй “Түшигт Хангай” ХХК-д дулаанаар ханган ажиллахыг хүссэн тухай 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 06/3682 дугаартай албан бичиг хүргүүлсэн

Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 3 дэд төв, 10 олон нийтийн дэд төвийн инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн шийдэл, хөрөнгө оруулалтын тооцоог боловсруулан нэгтгэж танилцуулга материалд тусгуулсан.

Барилга хот байгуулалтын яам, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Барилга, архитектурын сургуультай жил бүр хамтран зохион байгуулдаг эрдэм шинжилгээний УЛААНБААТАР УС-ЦЭВЭР ОРЧИН 2021 бага хуралд 09:00-18:00 хооронд оролцож Инженерийн бэлтгэл арга хэмжээний шугам сүлжээ



болон Ус хангамж ариутгах татуургын шугам сүлжээний одоогийн байдал, төлөвлөлт, шинэ технологи, усны аюулгүй байдал нэртэй илтгэл тавьж хэлэлцүүлж ажилласан.

#### *Ажлын хэсэгт орж ажилласан байдал :*

- Эрчим хүчний яамны сайдын 2020 оны 252 дугаар тушаалаар батлагдсан Техникийн нөхцөл олгох ажлын хэсэг
- Эрчим хүчний яамны сайдын 2021 оны А/85 дугаар тушаалаар батлагдсан Улаанбаатар хотын дулаан хангамжийн системийн горим ажиллагаанд үүсэж буй хүндрэлүүдийг тодорхойлох, дулаан эрчим хүчний хэрэглээ, эх үүсвэрүүдийн дулааны тоноглолыг өргөтгөн шинэчлэх шинэ техник технологи нэвтрүүлэх чиглэлээр санал боловсруулах, цаашид авах арга хэмжээг тодорхойлон дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг
- НЗД-ын 2021 оны А/68 дугаар захирамжаар байгуулагдсан “гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо”
- НЗД-ын 2021 оны А/429 дүгээр захирамжаар байгуулагдсан “Нийслэлийн хэмжээнд цэвэр усыг хэмнэх, саарал усны хэрэглээг нэмэгдүүлэх инноваци технологийн шийдлийг судлан нэмэгдүүлэх, холбогдох хууль эрх зүйн орчны судалгаа хийх, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- НЗД-ын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/142 дугаар захирамжаар Залуус орон сууцны хорооллыг байгуулах ажлыг нийслэлийн хэмжээнд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах, бэлтгэл арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг
- Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1255 дугаар захирамж, газрын даргын 2021 оны А/81 дугаар тушаалаар байгуулагдсан Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн



- барилгажуулах, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин барилгажуулах төслийн дэд ажлын хэсэг
- Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/28 дугаар захирамжаар Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгжээс хэрэгжүүлж буй Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар баригдаж буй Дэнжийн 1000, Сэлбэ дэд төвийн дулааны эх үүсвэрийг төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн сүлжээнд холбон хослуулан ажиллуулах судалгаа, тооцоо хийх ажлын хэсэгт
  - Эрчим хүчний яамны Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах талаар судлан, дүгнэлт гаргах ажлын хэсэгт шаардлагатай мэдээлэл, судалгааг боловсруулан танилцуулах үүрэг бүхий дэд ажлын хэсэгт
  - Барилга, Хот байгуулалтын яамны Нийслэлийн Засаг даргын 2021 оны өдрийн А/142 дугаар захирамжаар Залуус орон сууцны хорооллыг байгуулах ажлыг нийслэлийн хэмжээнд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах, бэлтгэл арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг
  - Барилга, Хот байгуулалтын Сайдын 2020 оны 225 дугаар тушаалаар батлагдсан Бохир



- усны Туул-1 коллекторын шугам сүлжээний барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх ажлын хэсэг
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан Усан сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүс, Ундны усны эх үүсвэрийн хориглолт хязгаарлалтын бүсэд өөрчлөлт оруулах цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

#### *Дотоод ажил, бусад:*

Тайлант хугацаанд дараахь бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг ханган тайлагнаж ажилласан. Үүнд:

- Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн биелэлт;
- Монгол Улсын Засгийн газрын 100 хоногт Барилга, хот байгуулалтын салбарт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт;
- 150 мянган айлын орон сууцны хөтөлбөрийн биелэлт;
- Нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт;
- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт;

- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;
- Барилга, хот байгуулалтын Сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020 онд засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтийг нэгтгэн тайлагнасан;
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон нийслэлийн Засаг даргын 2021 онд байгаль орчин, аялал жуулчлалын бодлогыг нийслэлд хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн тайлагнасан;
- Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан хянуулж, Захиргаа, санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.
- Байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгуулах хэлтсийн төсөл арга хэмжээний саналыг боловсруулан стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт хүргүүлэн нэгтгэсэн. Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.
- Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хэвийн төлөвлөлтийн талаар UBS телевизийн “Ажилсаг Улаанбаатар” нэвтрүүлгээр орж нэгдсэн мэдээллийг иргэдэд хүргэсэн.
- Иргэд аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн нэгж талбарын орчмын инженерийн шугам сүлжээний мэдээллийг тухай бүр гарган өгч ажилласан.

Хэлтсийн нийт албан хаагчид хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд тайлагнасан.

Хэлтсийн сар, хагас жилийн тайланг нэгтгэн танилцуулга материал бэлтгэн ажиллав.

Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, Байгууллагын архивын ажлын үндсэн заавар, МУ-ын стандарт “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн эмхтгэл”, Архив, албан хэрэг хөтлөлтийн систем, тусгай төрлийн баримттай ажиллах арга зүйг баримтлан Хэлтсийн хэмжээнд тайлант хугацаанд нийт 398 бичиг хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд үүнээс 163 хариутай албан бичиг байв.

Хэлтсийн албан бичиг шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9,5 хоног.

Хэлтсийн 2020 оны баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивд хүлээлгэн өгсөн байна. Үүнд :

✓ 2020 онд ирсэн албан бичиг	3 боть
✓ 2020 оны ажлын зургийн даалгавар	2 боть
✓ 2020 оны тендерийн бичиг баримт	2 боть

Цахим архив үүсгэх зорилгоор 2021 онд боловсруулагдсан ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг нэгтгэн сканердаж жагсаалт үүсгэн хөтөлсөн.

Нийслэлийн Архивын газарт байгууллагын архивыг хүлээлгэн өгөх ажлын хүрээнд 2013, 2014 оны 42 хайрцаг Архитектур төлөвлөлтийн даалгаврын хувийн хэргийг дугаарлан товьёглон, цахим архив үүсгэсэн.

Хэлтсийн хэмжээнд тайлант хугацаанд нийт 37 өргөдөл хүлээн авч 37 өргөдлийг шийдвэрлэсэн. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног, 5 цаг.

Худалдаа үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлж байгаа иргэдийн QR кодоор хянах үйл ажиллагааг зохион байгуулж байгаа байдалд нийслэлийн агентлаг, харьяа байгууллагуудын хяналт тавьж ажиллах хуваарийн дагуу 2021 оны 01 сарын 28, 29-ны өдөр ХУД-ийн 15 дугаар хороонд, 02 дугаар сарын 11, 13-ны өдрүүдэд ХУД-ийн 11 дүгээр хороо тус тус ажилласан.

Монгол улсын Засгийн газраас тэргүүлэх салбаруудад хэрэгжүүлэх 100 төсөл, арга хэмжээнд тусгуулах төсөл, арга хэмжээний хүрээнд ашиглалтын шаардлага хангахгүй барилгын дахин төлөвлөн барилгажуулах 96 барилгын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын төслийн танилцуулгыг бэлтгэв.

Агаарын бохирдолтой тэмцэх газрын боловсруулж буй Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.3 дахь хэсэгт заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хамтарсан тушаал, захирамжийн хүрээнд боловсруулж буй Агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журмыг шинэчлэн батлах тухай журмын төсөлд санал боловсруулж хуулийн хэлтэст хүргүүлсэн.

Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 3 дэд төв, 10 олон нийтийн дэд төвийн дэд бүтцийн төлөвлөлтийн шийдэл, хөрөнгө оруулалтын тооцоог бол Богдзонхав хөшөө цогцолбор төслийн гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл боловсруулж, хөрөнгө оруулалтын тооцоо гаргаж танилцуулга бэлтгэв.

#### *Сургалт, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байдал:*

*2021 оны байдлаар хэлтсийн албан хаагчид дараах сургалтад хамрагдсан байна. Үүнд:*

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ”
- Ус хангамжийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийн ариутгах татуурга, бохир ус зайлуулах туршлага, шинэ шийдлүүд
- Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг байгууллагын ажиллагаанд нэвтрүүлэх ач холбогдол, үр дүн
- БНХАУ-ын Элчин сайдын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсээс зохион байгуулсан “Дэд бүтэц ба барилга”, “Хөгжиж байгаа орнууд ба цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалт”
- Азийн хөгжлийн банкны “Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах хөтөлбөр” 2-р шат төслөөс зохион байгуулсан Эрчим хүчний хэмнэлттэй ногоон байгууламж
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас зохион байгуулсан “Улаанбаатар хотын хот нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн ашиглалтын нэгдсэн хяналт, удирдлагын цогц систем” “UB ENGINEERING” төсөл
- Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан Худалдан авах ажиллагаатай холбоотой шинэчилсэн журам, тендерийн жишиг баримт бичиг, цахим системийн танилцуулга

- Удирдлагын академиас зохион байгуулсан Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт "Алсын хараа-2050" сэдэвт сургалт
- GIZ Монголын Барилгын Зураг төсөл зохиогчдын холбооноос зохион байгуулсан "Барилгын эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх"
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвөөс зохион байгуулсан "Нүүрстөрөгч багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хотын хөгжилд шинжлэх ухаан, технологи, инновацыг хөшүүрэг болгох нь" сэдэвт сургалт

*Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Сургалт судалгааны төвөөс зохион байгуулсан дараах сургалтууд:*

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс зохион байгуулсан "Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж"-ийн саналыг төсөл арга хэмжээ бүрээр цахим системд оруулж, үнэлгээ хийх талаар сургалт
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад зориулсан хуулийн сургалт (МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, УБ хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга, Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан ublegal.mn сайтын танилцуулга)
- "Улс, нийслэлийн хөгжлийн бодлогын суурь үзэл баримтлал", "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Edoc системийн ашиглалт", "ERP системийн ашиглалт" сэдэвт нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагийн нэгжийн дарга нарт зориулсан багц сургалт
- "Албан бичгийн найруулга зүй", "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, eDoc, ERP систем ашиглалт, өргөдөл гомдлын систем" сургалт

*Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газраас зохион байгуулсан дараах сургалтууд:*

- "Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт ба төрийн албаны шинэтгэл" сэдэвт сургалт
- "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулахад чиглэсэн гарын авлага"-ыг танилцуулах сургалт
- "Төрийн албан хаагчийн манлайлал ба гүйцэтгэлийн менежмент" сэдэвт сургалт
- "Харилцааны ур чадвар" сэдэвт сургалт
- "Майер Бриггсийн төрөл илтгэгч" сэдэвт сургалт
- "Албан хаагчийн зөөлөн ур чадвар хөгжүүлэх туршлага" сэдэвт сургалт
- "Төрийн албаны сонгон шалгаруулалтын өнөөгийн байдал" сэдэвт сургалт
- "Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн цахим системийг ашиглах нь"
- Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, анхаарах асуудал
- "Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга" "7,4.10" арга зүйн сургалтын үр дүн" сэдэвт сургалт

- Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны зайн сургалтад тус тус хамрагдсан.

*Хянасан:*

*Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дарга*

*...../ Б.Оюунтуяа /*

*Тайлан бичсэн:*

*Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн*

*Ахлах мэргэжилтэн ...../ Ц.Лхамсүрэн /*